



**“ЖИ ӨҮ ЭЙЧ” ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД, ЦОГТЦЭЦИЙ,  
ХАНХОНГОР, МАНЛАЙ, БАЯН-ОВОО, НОМГОН, ЦОГТ-ОВОО СУМДЫН  
НУТАГТ ОРШИХ “НОМГОН-ІХ” БХГ-Т ТАЛБАЙН НҮҮРСНИЙ ДАВХАРГЫН  
МЕТАН ХИЙН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: 332/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5511844/

## АГУУЛГА

1.	Төслийн танилцуулга.....	3
1.1	Ерөнхий мэдээлэл .....	3
1.2	2023 оны эрэл хайгуулын ажлын арга, аргачлал ажлын хэмжээ .....	5
1.2.1	Геологийн судалгааны ажил.....	5
1.2.2	Өрөмдлөгийн ажил.....	6
1.2.3	Туршилтын олборлолт.....	12
1.2.4	Дээжлэлтийн ажил .....	12
1.2.5	Лабораторийн ажил.....	13
1.3	Туслах материал, ашиглалт.....	14
1.3.1	Ус ашиглалт .....	14
1.3.2	Хог хаягдал .....	16
2.	Байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч .....	17
3.	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч.....	21
4.	БОМТ-НИЙ гол зорилт, хамрах хүрээ .....	24
5.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	25
6.	Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө .....	27
7.	БОЯБ, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	34
8.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	34
9.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	34
10.	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө .....	35
11.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	37
12.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	39
13.	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	41
14.	БОМТБ-ийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	42
15.	2023 онд хэрэгжүүлэх БОМТ-ний нийт зардал.....	44
16.	Хавсралт материал .....	45
16.1	Аж ахуйн нэгжийн гэрчилгээ.....	46
16.2	Тусгай зөвшөөрөл.....	48
16.3	Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр .....	49
16.4	2023 оны хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв.....	50
16.5	БОАЖЯ-ны Ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2019, 2022 он.....	51
16.6	БОННУ, БОМТ (5 жил)-ний батлагдсан нүүр, 2019, 2022 он.....	53
16.7	2022 оны БОМТ-ний тайлангийн баталгаажсан нүүр.....	57
16.8	2022 оны нөхөн сэргээлтийн акт.....	58
16.8.1	Чичирхийллийн ажлын нөхөн сэргээлтийн тухай албан тоотууд .....	58
16.8.2	Хайгуулын өрөмдлөгийн талбайн нөхөн сэргээлтийн актууд.....	61
16.8.3	Туршилтын олборлолтын талбайг үйл ажиллагаа түр зогссон тухай .....	64

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Талбайн хэмжээ, сумаар .....	4
Хүснэгт 2. Номгон IX талбайн 2023 оны хайгуулын цооногуудын солбицол .....	6
Хүснэгт 3. Усны тооцоо, жилээр .....	15
Хүснэгт 4. Сумдын хүн ам, өрхийн үзүүлэлт .....	21
Хүснэгт 5. Гол болон болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим .....	22
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	25
Хүснэгт 7. Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө.....	28
Хүснэгт 8. Таримал хайласыг услах норм .....	32
Хүснэгт 9. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	41
Хүснэгт 10. БОМТБ-ийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	42
Хүснэгт 11. 2023 оны БОМТ-ний нийт зардал,төг.....	44

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Номгон-IX” талбайн байршил .....	4
Зураг 2. “Номгон-IX” талбайд хамаарах сумдын хил хязгаар, байршил .....	5
Зураг 3. “Номгон-IX” талбай дах Цэций хайрхан дэд талбайн геологийн зураг .....	6
Зураг 4. 2023 онд төлөвлөсөн өрөмдлөгийн байршлын зураг .....	7
Зураг 5. 2023 онд төлөвлөсөн геологийн зураглалын төлөвлөлтийн зураг .....	8
Зураг 6. IFOT хэмжилтийн багаж төхөөрөмж, түүний схем .....	9
Зураг 7. Даралт хэмжилтийн ерөнхий мэдээлэл.....	10
Зураг 8. Даралт хэмжилтийн схем .....	11
Зураг 9. “Номгон-П” цооног өрөмдөж буй байдал. Мажор Дриллинг.....	12
Зураг 10. Дээжлэлтийн явц.....	13
Зураг 11. Хог хаягдал ангилах ялгах жишээ.....	16
Зураг 12. Хайгуулын талбай орчмын өндөршлийн зураг.....	17
Зураг 13. 1 настай суулгацыг суулгаж тарих бүдүүвч.....	31
Зураг 14. 2-3 настай суулгацыг тарих бүдүүвч.....	31
Зураг 15. Хайласыг үрээр тарих бүдүүвч.....	32
Зураг 16. Ойн зурвасанд мод тарих бүдүүвч .....	33
Зураг 17. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө .....	35
Зураг 18. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	37
Зураг 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	39

## 1. Төслийн танилцуулга

### 1.1 Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ний өдрийн 265 дугаар тогтоолыг үндэслэн, Ашигт Малтмал, Газрын Тосны Газар (цаашид АМГТГ гэх)-тай Австрали улсын хөрөнгө оруулалттай “Жи Өү Эйч” ХХК “Номгон-IX” талбайд газрын тосны уламжлалт бус эх үүсвэр болох нүүрсний давхаргын метан (НДМ) хийн хайгуул, ашиглалттай холбоотой үйл ажиллагаа эрхлэх Бүтээгдэхүүн хуваах гэрээ (цаашид БХГ гэх)-г 2018 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан.

**Төслийн нэр:** “Номгон-IX” БХГ-т талбайд “Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын ажил гүйцэтгэх” төсөл

**Төслийн зорилго:** Өмнөговь аймгийн Баян-Овоо, Ханхонгор, Ханбогд, Цогтцэций, Цогт-Овоо, Номгон, Манлай сумдын нутагт орших “Номгон-IX” хайгуулын тусгай зөвшөөрлийн 2,988,005.67 га (29,880км<sup>2</sup>) талбайд НДМ хий хайх, нээх, ашиглах.

**Төслийн ач холбогдол:** Энэхүү төсөл нь Монгол Улсын эдийн засгийн шинэ тулгуур салбар болон хөгжих бөгөөд дотоодын эрчим хүчний хэрэгцээг бие даан хангаж, гадаад улсуудын хамаарлаас бүрэн салах нөхцөл бүрдэнэ. Хайгуулын төсөл амжилттай хэрэгжсэнээр ажлын байр бий болох, орон нутгийн төсөвт хувь нэмэр оруулах болно.


“Жи Өү Эйч” ХХК-ийн хэрэгжүүлэх төслийн Өмнөговь аймагт үзүүлэх хувь нэмэр:

- БХГ-ний хүрээнд жил бүр орон нутгийн хөгжилд туслалцаа үзүүлнэ.
- Нутгийн захиргаатай хамтран хамтын ажиллагааны гэрээний хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- Төслийн талбайд байгаль орчны төлөв байдлыг тодорхойлж, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд тусгагдсан арга хэмжээг тухайн жилийн байгаль орчны менежментийг төлөвлөгөөнд тусган цаг тухайд нь хэрэгжүүлж ажиллана.
- Олон улсад ашиглагддаг, БО-д ээлтэй шинэлэг технологи, арга ухааныг Монгол Улсдаа нэвтрүүлж, Монгол иргэдийг мэргэшүүлэн бэлтгэнэ.
- Ирээдүйд тогтвортой хөгжлийг орон нутагт, улсдаа бий болгоно.

**Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:**

- “Жи Өү Эйч” ХХК
- Улсын бүртгэлийн дугаар: 9019063023
- Регистрийн дугаар: 5511844
- Хаяг: Улаанбаатар хот,
- Утас: +976-77552011, 88042165
- E-mail: [Achitsan.Buyannemekh@goldenhorde.com.au](mailto:Achitsan.Buyannemekh@goldenhorde.com.au)
- Вэб: [www.goldenhorde.com.au](http://www.goldenhorde.com.au)

**Төслийн талбайн байршил:** Номгон-IX талбай нь засаг захиргааны хувьд Өмнөговь аймгийн Номгон, Баян-Овоо, Ханбогд, Манлай, Цогтцэций, Ханхонгор, Цогт-Овоо сумдын нутгийн 2,988,005.67 га (29,880км<sup>2</sup>) талбайг хамарна.




Зураг 1. “Номгон-IX” талбайн байршил

“Номгон-IX” талбайн хамаарах сум тус бүрийн газар нутгийн хэмжээг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Талбайн хэмжээ, сумаар

№	Аймгийн газар нутгийн хамаарах талбай	Сум	Сумдын нутгаас хамаарах хэмжээ, га	Хувь
1.	Өмнөговь: 2,988,005.67 Га	Номгон	690693.08	23.1%
2.		Баян-Овоо	671321.06	22.5%
3.		Ханхонгор	660294.78	22.1%
4.		Цогтцэций	527716.01	17.6%
5.		Ханбогд	263639.15	8.8%
6.		Манлай	162842.71	5.5%
7.		Цогт-Овоо	11498.88	0.4%

“Номгон-IX” талбай нь дээрх сумдын нийт газар нутгийн 36.8 хувийг эзэлж байна.



**Зураг 2. “Номгон-IX” талбайд хамаарах сумдын хил хязгаар, байршил**


## 1.2 2023 оны эрэл хайгуулын ажлын арга, аргачлал ажлын хэмжээ

Өрөмдлөг, цооногийн давхаргын туршилт, лабораторийн ажил, туршилтын олборлолтын ажил хийгдэнэ.

### 1.2.1 Геологийн судалгааны ажил

#### 1.2.1.1 Геологийн эрэл, зураглалын ажил

Энэ судалгаагаар нүүрсний гаршуудыг олж үнэлэн цооногийн ба сейсмийн шугамуудын байршлыг тогтоох чиглэл тодорхойлно. Өмнөх онуудын хайгуулын ажлын явцад нүүрсний давхаргын метан хийн хэтийн төлөвийг тодорхойлж үнэлэхэд хүндрэлтэй байлаа. Цаашдын үйл ажиллагаагаар 300 – 800 метрийн блок дах нүүрсний давхаргын хий бүхий шинэ талбайнуудад хэтийн төлвийг үнэлж тодорхойлно. Цаашид өргөн цар хүрээтэй талбайн зураглалын ажлыг хийх болно. “Жи Өү Эйч” ХХК нь 2023 онд 3-4 талбайд 1:25000, 1:10000 масштабтай эрэл зураглалын ажлыг хийхээр төлөвлөж байна.



**Зураг 3. “Номгон-IX” талбай дах Цэций хайрхан дэд талбайн геологийн зураг**

Нийт “Номгон-IX” талбайд эхний 3 жилд нийт талбайн 1.8%-д буюу 530 км<sup>2</sup> талбайд хайгуул, өрөмдлөгийн ажил хийжээ. Цаашид хайгуулын ажлыг эрчимжүүлэхэд зураглалын ажлыг хийж гүйцэтгэх нь чухал ач холбогдолтой байна.

### 1.2.2 Өрөмдлөгийн ажил

#### 1.2.2.1 Цооногийн төрөл, байршил геологийн даалгавар зорилго

“Жи Өү Эйч” ХХК нь 2023 онд “Номгон-IX” талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын нийт 6000 тууш метр (ойролцоогоор 9-10 цооног) өрөмдөхөөр төлөвлөсөн.

Цооног өрөмдөхөд хамгийн тохиромжтой байршлыг тогтоохын тулд чичирхийллийн болон бусад мэдээлэл, өгөгдөлд дүн шинжилгээ хийнэ. Чичирхийллийн хайгуул судалгааг Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций, Баян-Овоо, Номгон, Манлай сумдын нутагт 2022 онд хийсэн ба тус онд хийгдсэн геологийн зураглал болон хайгуулын өрөмдлөгийн үр дүнгээс хамаарч цооног өрөмдлөгийн байршил өөрчлөгдөх магадлалтай бөгөөд 2023 оны хайгуулын ажлын төлөвлөгөөний дагуу дараах цооногуудыг өрөмдөхөөр урьдчилсан төлөвлөсөн. Үүнд:


- Эрлийн цооног – 4
- Үнэлгээний цооног – 5 байна. Эдгээр цооногууд нь өрөмдлөгийн үед газар дээрээ бага зэргийн өөрчлөлт орж болно.

#### **Хүснэгт 2. Номгон IX талбайн 2023 оны хайгуулын цооногуудын солбицол**

№	Уртраг	Өрөгрөг
1	42° 56' 10.9839" N	105° 04' 21.9068" E
2	42° 56' 12.3342" N	105° 06' 02.3742" E
3	42° 55' 48.7500" N	105° 13' 19.6981" E
4	42° 55' 36.0766" N	105° 14' 14.5925" E
5	42° 52' 59.2200" N	105° 41' 48.4400" E
6	42° 49' 27.8977" N	105° 11' 18.1154" E
7	42° 51' 54.4484" N	104° 48' 55.4655" E

8	42° 52' 45.1997" N	104° 38' 09.6420" E
9	42° 58' 29.7318" N	105° 12' 13.5671" E

Хайгуулын цооногуудын гүн ойролцоогоор 600м-ээс 800м байхаар тооцсон. Тухайн талбайн геологийн нөхцөлөөс хамаарч дээд тал нь 1000м хүрч болно. Нийт төлөвлөсөн цооногийн тууш метр нь ойролцоогоор 6000м болж байна.




Зураг 4. 2023 онд төлөвлөсөн өрөмдлөгийн байршлын зураг



“НОМГОН IX” СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ГЕОЛОГИЙН ЗУРАГ

Масштаб 1:500000



Зураг 5. 2023 онд төлөвлөсөн геологийн зураглалын төлөвлөлтийн зураг

**1.2.2.2 Өрөмдлөгийн аргачлал**

2023 оны хувьд өрөмдлөгийн ажлыг төлөвлөхдөө хайгуул үнэлгээний гэж ангилахгүйгээр эрлийн болон хайгуулын цооног өрөмдөхөөр төлөвлөсөн. Нийт төлөвлөсөн цооногууд эрлийн цооног үртэс дээжлэлттэй, хайгуулын цооног чөмгөн дээжлэлттэй өрөмдөхөөр шийдвэрлэсэн.

**Үртэс дээжлэлттэй буюу эрлийн цооног өрөмдлөг**


Уг өрөмдлөгийн аргачлал нь зардал багатай, хий өгөлтийн туршилт хийгдэхгүй.

- Зардал ба хугацаа бага зарцуулна;
- Ерөнхий геологи, литологийн мэдээлэл олж авах, хайгуулын ажил хийгдээгүй томоохон талбайд нүүрсний үе нэвтрэхэд хямд төсөр;
- 2D сейсмийн үр дүнтэй уялдуулахад ач холбогдолтой;
- Өрөмдлөгийн энгийн практик ашиглагдана.

**Чөмөг дээжлэлттэй буюу хайгуул үнэлгээний өрөмдлөг**

Чөмөг дээжлэлттэй өрөмдлөг хийгдэж хий агуулсан нүүрс үе нэвтэрвэл хий өгөлтийн (desorption) ба нэвчээмжийн (IFOT) туршилтууд хийгдэнэ. Эдгээр туршилтыг нүүрсний давхарга нэвтэрсэн үе дээр хийнэ.

- Америкийн (ASTM D7569) стандартын дээжлэлт ба хийн десорбцийн (Q1+Q2+Q3) анализ хийгдэнэ.
- Хромотографийн шинжилгээ хийнэ. Нүүрсний дээжид петрографийн, хий өгөлтийн зэрэг зохих анализууд хийгдэнэ;
- Давхаргын даралтын туршилтыг (IFOT) нүүрсний давхаргад гүйцэтгэж нүүрсний нэвчээмж болон ан цавыг тодорхойлно;



**Зураг 6. IFOT хэмжилтийн багаж төхөөрөмж, түүний схем**

Тухайн цооногт DST туршилтын төхөөрөмж цахим бичигчийн хамт, цооногийн 3 ширхэг хэмжигч ба гадаргуугийн хэмжигчийг төхөөрөмжүүдийн хамт угсарч цооног руу буулгана. Эдгээр нэмэлт хэмжигчүүд цооногийн төхөөрөмжүүдийн ажиллагаа, сумны болон пакерийн шингэн алдалтыг хянах зориулалттай. Цэвэр усыг цооног руу шахаж, дараа нь хэдэн цаг давхаргын даралтын туршилтыг хэмжиж, хэдэн цагийн хугацаанд цооногийг битүүмжилнэ. Үүний дараа дахин ус шахаж, дараа нь давхаргын даралтын уналыг хэдэн цагийн турш хэмжинэ. Үүний дараа DST-ийн цооногийн төхөөрөмжийг өргөж даралт хэмжигчийн хамт гадаргууд гаргана.

Inflate Straddle Drill Stem Test		Qteq				
DST Report						
<b>Well Name:</b>	Nomgon 1	<b>Formation Name:</b>	Tavan Tologi FM (Upper) *300*			
<b>Test Number:</b>	IFOT 4	<b>Well Location:</b>	Mongolia - Gobi			
<b>Interval From:</b>	269.50 m	<b>Interval To:</b>	282.33 m			
<b>Job Number:</b>	02-13-021-0002	<b>Test Type:</b>	Injection and Fall-off			
<b>Day DST Supervisor:</b>	Michael Siefert	<b>Night DST Supervisor:</b>	Ryan Gee			
<b>Day DST Operator:</b>		<b>Night DST Operator:</b>				
<b>Day EMT Supervisor:</b>		<b>Night EMT Supervisor:</b>				
Client & Rig Information						
<b>Client:</b>	Elixir Energy	<b>Rig Company:</b>	Erdenn Drilling LLC			
<b>Day OCR:</b>	Chris Aanensen	<b>Day Rig Manager:</b>	Mr Sunny Bayansan			
<b>Night OCR:</b>	-	<b>Night Rig Manager:</b>	-			
<b>OCR Ph Number:</b>	+ 976 80 452011	<b>Rig Ph Number:</b>	-			
<b>OCR E-Mail:</b>	<a href="mailto:chris@ellehcor.mn">chris@ellehcor.mn</a>	<b>Rig E-Mail:</b>	-			
<b>Geologist:</b>	-	<b>Rig Type:</b>	Atlas Copco Boyles C8C			
<b>Mobilised by:</b>		<b>Rig Name:</b>	-			
<b>Post Job Contact:</b>	Michael Siefert	<b>Rotary Table Height:</b>	0.75 m			
Drilling Information						
<b>Total Depth</b>	425.5 m	<b>Hole Size:</b>	96 mm			
<b>Mud Type:</b>	KCL/Polymer	<b>Mud Weight:</b>	8.7-8.8 ppg			
<b>Hole Condition:</b>	Good	<b>Losses / Returns:</b>	N/A bbls			
<b>Pre-DST Ops:</b>	Logging	<b>Mud Pill:</b>	N/A ppg			
Drill Rod Information						
Type	Connection	Quantity	OD	ID	Average Length	Volume
Drill Rods	HRQ		77.8	88.9	3 m	
Collars					m	
Pup Joints					m	
Other					m	
General Test Notes						

Зураг 7. Даралт хэмжилтийн ерөнхий мэдээлэл

Inflate Straddle Drill Stem Test							Qteq
Bottom Hole Assembly & Pipe Tally							
Well Name:	Nomgon 1		Formation Name:	Tavan Tologi FM (Upper) "300"			
Test Number:	IFOT 4		Total Depth:	425.5 m			
Interval From:	269.50	m	Interval To:	282.33 m			
Total Interval:	12.83	m	Rotary Table:	0.75 m			
Description	S/N	ID (in)	OD (in)	Length (m)	Depth (m)	Tool Schematic	
Stick Up					-1.60		
Rig Pup Joint(s)	Quantity: 0	3.060	3.500	0.00	-2.35		Drill Rods
Rig Drill Rod(s)	Quantity: 89	3.060	3.500	267.00	-2.35		
Rig Collars(s)	Quantity: 0	3.060	3.500	0.00	264.65		
Cross Over Sub				0.18	264.65		Fluid Gauge
Fluid Sub & Gauge	19897		3.385	0.84	264.83		
Stage Tool			3.385	2.59	265.67		
Top Packer Stick Up			3.385	1.24	268.26		
Top Packer Seal Depth	Element #	IP161211HP2036			269.50		Stage Tool
Top Packer Stick Down & Flow Sub			3.385	0.44	269.94		
Outside Gauge Carrier	19920	19921	3.385	1.04	270.98		Bottom Packer
EM Telemetry			3.385	0.00	270.98		
Spacing	Quantity: 5	2m each		3.385	10.00		
Spacing	Quantity: 1	1m each		3.385	1.00		281.98
Spacing	Quantity: 0	0.3m each		3.385	0.00		281.98
Bottom Packer Stick Up			3.385	0.35	282.33	Flow Sub & Top Packer	
Bottom Packer Seal Depth	Element #	IP101111DL1915			282.33		
Bottom Packer Stick Down & Gauge	19934		3.385	1.38	283.71		
					End Drill String	283.71	Flow Sub & Top Packer
Rig Supplied Equipment				Quantity	Length (m)	EM Telemetry (Optional)	
Rig Pup Joint(s) above BHA				0	0.00		
Rig Drill Rod(s) above BHA				89	267.00		
Rig Collars(s) above BHA				0	0.00		
Rig Drill Rod(s) in Interval				0	0.00	Bottom Packer Spacing	
Rig Drill Rod(s) in Interval				0	0.00		
Water Cushion							
Fluid Medium				Water			
Cushion Percentage				100 %			
Cushion Meters				267 m			
Rig Collars & Drill Rods				89			
Fluid Volume				1,267 litres			
						Below Straddle Gauge	

Зураг 8. Даралт хэмжилтийн схем

### 1.2.3 Туршилтын олборлолт

Туршилтын олборлолтын хөтөлбөр 2022 оны 11 сард эхэлсэн бөгөөд туршилтын олборлолтын цооног өрөмдсөнөөс хойш цооногийн тоноглол болон бусад ажлыг хийж дууссаны дараа 6 сарын турш хяналтын ажлыг явуулдаг журамтай. 2022 онд ойролцоогоор 1 сарын хугацаанд туршилтын олборлолтын хяналтыг ажлыг хийж гүйцэтгэж түр хугацаанд битүүмжлэн хаасан байгаа. Журмын дагуу 2023 онд 5 сарын хугацаанд туршилтын олборлолтын хяналт, хэмжилтийн ажлыг үргэлжлүүлэхээр төлөвлөж байна. Туршилтын олборлолтын хяналт хэмжилтийг МонБаг компанийн операторуудын баг үргэлжлүүлэн гүйцэтгэх бөгөөд өдөр тутмын мэдээг АМГТГ-т хүргүүлсээр байна.




**Зураг 9. “Номгон-П” цооног өрөмдөж буй байдал. Мажор Дриллинг**

Туршилтын олборлолтын хугацаанд цооногийн давхаргын ундаргыг сайжруулах эрчимжүүлэх, цооногийн шахуурга хяналт хэмжилтийн төхөөрөмжүүдийн техникийн засвар үйлчилгээ хийгдэнэ. Эдгээр ажлуудын давтамжийг өөрөөр хэлбэл туршилтын олборлолтын нийт хугацаанд хэдэн удаа хийгдэх зэрэг нь урьдчилан тодорхойлох боломжгүй байна. 5 сар хүртэлх хугацаанд туршилтын олборлолтыг гүйцэтгэсний дараа нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу мэргэжлийн баг хийж гүйцэтгэнэ. Түүнчлэн энэ туршилтын хугацаанд олж авсан тоон өгөгдлүүдийг ашиглан тухайн төслийн талбайн хийн агууламж болон нөөцийг тогтоох ажил хийгдэх бөгөөд тухайн талбайг цаашид хэрхэн ашиглах талаар тодорхой саналыг хүргүүлэхээр төлөвлөж байна.

### 1.2.4 Дээжлэлтийн ажил

Өрөмдлөгийн ажлын эхнээс нүүрсний чанарыг тодорхойлох, дээжлэх арга техникийг сонгох, шинжилгээг үнэн зөв хийх, хийг тогтоох, шинжилгээний хариунд хяналт тавих бүх нөхцөлийг хангах ёстой. Иймээс бид нүүрсний дээжийг бэлтгэж хийн дээж авахын тулд маш сайн бэлдэж, тухайн сонгосон дээжний фото зургийг баримтжуулж дээжлэлтийн явцад геологич болоод лабораторийн ажилчдад зааврын дагуу маш хянамгай дээжийг холиж будлиулахгүй байхыг байнга анхааруулан хяналт тавьж ажиллах болно. Хийн дээжлэлтийг тухайн нүүрсний давхаргаас шалтгаалж 0.30см – 0.50см урттайгаар нүүрсний давхарга бүрээс сонгож авна. Бусад лабораторийн дээжлэлтийг цооног өрөмдөж дууссаны дараа тодорхой сонгосон интервалаас сонгож авна.



Зураг 10. Дээжлэлтийн явц

### 1.2.5 Лабораторийн ажил

Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын шатанд бусад улсуудад хийгдэж буй шинжилгээнүүдийг хийлгэж байна. Хээрийн явуулын лабораторид хийн агуулга, найрлага хэмжих, нүүрсэнд петрографийн шинжилгээ хийлгэж, органик гарлыг тодорхойлуулах, хийн ханалтын зэрэг, хийн гарал үүслийг тодорхойлуулах нь нүүрсний метан хийн хайгуулыг амжилттай, үр дүнтэй болгоход чухал ач холбогдолтой.

Хийн ханалын шинжилгээ, хийн гарал үүсэл тодорхойлуулах шинжилгээг Монгол улсад хийлгэх боломжгүй байгаа тул гадаад улсуудад, тухайлбал БНХАУ-д хийлгэх бол, бусад шинжилгээнүүдийг тухайлбал хийн агуулга, найрлага хэмжих, нүүрсэнд петрографийн шинжилгээ, техникийн шинжилгээ зэргийг Монгол улсад хийлгэж байна.

Дараах төрлийн лабораторийн шинжилгээ хийгдэнэ.

- Хийн хроматографийн анализ
- Петрографийн анализ
- Хээрийн (Desorption) анализ
- Хий өгөлтийн (Adsorption) анализ
- Палинологийн шинжилгээ
- НАWK пиролизын шинжилгээ
- Нүүрсний ерөнхий шинжилгээ буюу Proximate анализ
- Усны бүрэн шинжилгээ
- Геологийн нас тодорхойлох буюу палинологийн шинжилгээ
- Тунамал чулуулгийн судалгаа

### 1.3 Туслах материал, ашиглалт

Нүүрсний давхаргын метан хийн хайгуул судалгааны үед дизель түлш, бентонит өрөмдлөгийн шатанд хэрэглэх химийн бодис ашиглах бөгөөд эдгээр өөр туслах материал болон химийн бодис, цацраг идэвхит бодис ашиглахгүй.

- Дизель түлш - цооног өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашиглагдах хүнд машин, техникт ашиглагдахаас гадна хайгуулын болон өрмийн кемпийн цахилгааны эх үүсвэр болох дизель моторт хэрэглэгдэнэ.
- Бентонит - өрөмдлөгийн үйл ажиллагаанд цооногийн нүхний ханын нурултаас хамгаалан ханыг бэхжүүлэх хэрэглэнэ.
- Туслах материал – өрөмдлөгийн шавар уусмалд бага хэмжээгээр нэмэх угаалгын бодисууд (СНР - Anionic Polymer, Super gel – Bentonite, АМС Pac R, АМС Pac L, АУS–Trol, Potassium chloride, Clay doctor, Core well, Det Xtra, Soda ash, хан bore) өрөмдлөгийн нэвтрэх хурд, чанар, цооногийн хананы нурултаас сэргийлэхэд ашиглагдана.
- Цемент – цооногийг битүүмжлэн хаахад хэрэглэнэ.
- Машин техник, тээврийн хэрэгслийн түлш, автобензин, тосолгооны материалын хангамжийг хээрийн ажил гүйцэтгэх газрын ойр орчмын сумын төв, суурин газраас худалдан авах ба тусгайлсан хадгалах агуулах, сав байршуулах шаардлагагүй, зориулалтын цистернээр тээвэрлэн авчирч, талбайд байршуулна. Харин цемент, бентонит СНР - Anionic Polymer, Super gel – Bentonite, АМС Pac R, АМС Pac L, АУS–Trol, Potassium chloride, Clay doctor, Core well, Det Xtra, Soda ash, хан bore зэрэг зориулалтаар өрмийн цементац, цооног битүүлэх, өрмийн шавар уусмал угаах ашиглана.

“Жи Өү Эйч” ХХК нь 2023 онд “Номгон-IX” талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын нийт 6000 тууш метр (ойролцоогоор 9-10 цооног) өрөмдөхөөр төлөвлөсөн.

#### 1.3.1 Ус ашиглалт

**Ажлын хэмжээ:** Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын ажлын 2023 оны хөтөлбөр төсвийн хүрээнд “Жи Өү Эйч” ХХК нь 2023 онд “Номгон-IX” талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын нийт 6000 тууш метр (ойролцоогоор 9 цооног) өрөмдөхөөр төлөвлөсөн.

**Усны тооцоо:** Энэ жил чичирхийллийн судалгаа хийгдэхгүй бөгөөд хэрэв чичирхийллийн судалгаа хийгдэхээр бол уг судалгаанд технологийн хэрэгцээний ус ашиглалт байхгүй, зөвхөн ажилчдын унд-ахуйд хэрэглэнэ. Харин өрөмдлөгийн шатанд технологийн болон ажилчдын унд-ахуйн хэрэгцээний цэвэр ус шаардлагатай. Ус ашиглалтын хэмжээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А-301 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ыг ашиглан 2, 12, 13-р хавсралтын дагуу тооцлоо.

### Хүснэгт 3. Усны тооцоо, жилээр

Өрөмдлөг	Хэмжих нэгж	Тууш метр	Усны хэрэглээ жил/м3	Нэг хоногт зарцуулах усны хэмжээ, м3
<b>Өрмийн ажилд ашиглах усны тооцоо</b>				
Хайгуулын өрөмдлөгийн цооногийн тоо, (9-10 цооног)	ширхэг	9	6000/100*10=600	600 /180=3.33
Хайгуулын өрөмдлөгийн хэмжээ	тууш метр	6000		
100 тууш метр хэрэглэх усны хэмжээ	м3	10		
1 Өрөмдлөг хийх хоногийн тоо (14-30)	өдөр	20		
Хайгуулын ажлын өрөмдлөг хийх өдөр	өдөр	180		
<b>Унд ахуйд хэрэглэх усны тооцоо</b>				
Өрмийн ажилд ажиллах хүний тоо	хүн	60	60*180*0.02=216	216/180=1.20
Өрмийн ажил хийгдэх хоног	өдөр	180		
Туршилт олборлолтын талбайд ажиллах хүний тоо	хүн	15	15*152*0.02=45.6	45.6/152=0.30
Туршилт олборлолтын талбайд ажиллах өдөр	өдөр	152		
Нэг хүний хоногт хэрэглэх усны хэмжээ	м3	0.02		
<b>Ногоон байгууламжид ашиглах усны тооцоо</b>				
Тарих модны тоо (2023 онд 2000 мод + 2022 онд амжилтгүй ургасан нөхөн тарилтын 113 мод)	ширхэг	2113	2113*8*0.04=955.84	
Мод услах давтамж	удаа	8		
Усалгааны норм	М3	0.04		
<b>Нийт</b>			<b>1,817.44</b>	

Усны тухай хуулийн 28.4-т зааснаар “Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

28.6.Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоометрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоометр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоометрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.

28.11.Энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ.

**Усны эх үүсвэр:** Хээрийн ажлын шатанд технологи болон ахуйн хэрэгцээт цэвэр усыг цооног өрөмдөх байршилд хамгийн ойр орших орон нутгийн худгаас зөөвөрлөн авна. Зарим үед ажилчдын ундны усыг савлагаатай цэвэр усаар хангана.



### 1.3.2 Хог хаягдал

**Ахуйн хог хаягдал:** Өрөмдлөгийн хээрийн ажлын шатанд ажилчдын ахуйн хэрэглээнээс энгийн хаягдал гарна. Ангилан ялгах боломжтой, битүүмжлэлтэй хогийн саванд хуримтлуулж, орон нутгийн зөвшөөрөгдсөн цэгт тээвэрлэн зайлуулна.

Хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээг орон нутгийн захиргааны байгууллагатай хийж, тогтоосон төлбөр хураамжийн дагуу төлбөр төлөх.

Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгаснаар хог хаягдал исэлдэж, үнэр орох, орчны бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлнэ. Мөн овор хэмжээг багасгах давуу талтай.



**Зураг 11. Хог хаягдал ангилах ялгах жишээ**

**Үйлдвэрлэлийн хог хаягдал:** Сав баглаа боодол (бентонит болон цементийн уут, тос тосолгооны материалын сав г.м), шавар уусмал, ашигласан дугуй зэргийг хамруулна. Дахин ашиглах боломжтой дугуйг хэрэглэгчид өгөх, өрмийн шингэн хаягдлын санг ажил дууссаны дараа техникийн нөхөн сэргээлт хийх, бусад хаягдлыг дахин боловсруулах эсвэл хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт нийлүүлнэ.

**Аюултай хог хаягдал:** Өрөмдлөгийн судалгааны үед ашигласан тос тосолгооны материал гарч болзошгүй. Хэрэв ашигласан тосны хаягдал гарсан тохиолдолд тусгай саванд цуглуулж, ажил дууссаны дараа ийм төрлийн хаягдал хүлээн авах газар нийлүүлнэ. Мөн хээрийн ажлын бүх үе шатанд ажилчдын ахуйн хэрэглээнээс (гар чийдэн, утас, аппарат г.м) хаягдал баттерей гарч болзошгүй. Хэрэв гарсан бол тусгай саванд цуглуулж, Хог хаягдлын үндэсний холбоонд хүлээлгэн өгнө.


## 2. Байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч

**Гэрээт талбайн байршил, засаг захиргааны харьяалал:** “Номгон-IX” талбай нь засаг захиргааны хувьд Өмнөговь аймгийн Номгон, Баян-Овоо, Ханбогд, Манлай, Цогтцэций, Ханхонгор сумдын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш ойролцоогоор 600 км-т орших бөгөөд Улаанбаатар-Өмнөговь чиглэлийн төв замаас 50 орчим км зайд байрлана.

Энэ бүс нутагт сүүлийн жилүүдэд томоохон үйлдвэр, үйлдвэрлэлийн район байгуулагдаж байгаа тул уурхайгаас олборлох нүүрсний хэмжээг нэмэгдүүлэх боломж өндөр ба гадаад зах зээлийн таатай бүсэд хамаарах юм. Төслийн талбайн орчимд “Эрдэнэс Тавантолгой” ХХК-ийн Цанхийн зүүн болон баруун хэсгийн уурхай, “Энержи ресурс” ХХК-ийн Ухаа худгийн уурхай, Орон нутгийн өмчит “Таван Толгой” ХК-ийн уурхай, “Оюу толгой” ХХК-ийн уурхай зэрэг уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн олон төсөл үйл ажиллагаа явуулж байна.

### Хайгуулын талбайн физик газарзүйн нөхцөл

**Уул зүй:** Газарзүйн нөхцөлийн хувьд энэхүү газар нутаг нь Монгол Улсын өмнөд хэсэгт улсын хилийн орчимд урдаас хойш сунаж тогтсон нам уулс, тал хөндий бүхий говь цөлийн бүсэд хамаарагдах бөгөөд далайн түвшнээс дээш 960-1136.9 хүртэлх метрийн өндөрт өргөгдсөн гүвээ, жижиг толгодорхог талархаг газарт оршино. Төсөл хэрэгжиж буй орчмын нутагт хамгийн өндөр цэг нь Баруун тогоо овоо (1136.9 м), хамгийн нам цэг нь Цагаан хадын худаг (1014.0 м) юм. Мөн нутгийн орчимд Далан шар уул (1113.6 м), Гурван Зээрд уул (1100.0 м), хил дээрх Хар хушууны овоо (1095.2м), тэр орчмын (1086.4м), (1069.0м) зэрэг тоот өндөрлөг бүхий нам уул толгод бий. Нам уулын баруун хойт хэсэгт Зээрдийн худаг байх ба түүний баруун урд хэсгээр далайн түвшнээс дээш 1025.4 метрийн өндөртэй эх чулуулгийн илэрц бүхий толгой байна.



**Зураг 12. Хайгуулын талбай орчмын өндөршлийн зураг**

**Уур амьсгалын ерөнхий тойм:** Халуун зунтай, хуурайвтар уур амьсгалын мужид цасгүй, зөөлөвтөр өвөлтэй мужид хамаарна. Ус чийг багатай, хуурай уур амьсгалтай. Агаарын температур нь олон жилийн дунджаар Өмнөговийн бүс нутагт 1-р сард  $-14.9^{\circ}$ , 7-р сард  $21.1^{\circ}$

байна. Агаарын чийгшилт багатай жилд дунджаар 45-50% байгаа нь хуурайвтар болохыг харуулна. Хур тунадасны хэмжээ дунджаар 127.1мм байдаг ба үүний 70-80% нь 7-8 дугаар сард унадаг. Өвөл цас маш бага, цасан бүрхүүл бараг тогтдоггүй бөгөөд 1-2см ихдээ 10см зузаантай байна. Хоногийн хэмийн хэлбэлзэл ихтэй учир салхи, шороон шуурга ихтэй. Салхины дундаж хурд 4-6 м/сек, хамгийн их салхилалт хавар тохиодог бөгөөд дунджаар 6 м/сек, жилд дунджаар 30-35 хоног 4 м/сек хүртэл цасан ба шороон шуургатай өдрүүд тохиолддог.

Хээрийн судалгааны ажлыг аль ч улиралд гүйцэтгэж болох ба (цасгүй боловч хүйтэн, салхи ба шороон шуургатай үед хүндрэл үүсдэг), тохиромжтой хугацаа нь 3 сараас 11 сар дуустал үргэлжилнэ.

**Геологийн тогтоц ба геоморфологи:** Тус дүүрэг нь геологийн тогтцын хувьд Говь-Хянганы структур формацын бүсэд хамаарагдах ба хожуу карбон, түрүү пермийн вулкан-плутон комплекс өргөн тархалттай юм. Дүүргийн хэмжээнд дунд-дээд девоны Цэцгэршанд формацын галт уулын тунамал, доод карбоны Ихшанх формацын тунамал-вулканоген, дээд карбон-доод пермийн Дөш-Овоо формацын галт уулын чулуулаг, доод пермийн Цогтцэций формацын галт уулын тунамал хурдас, дээд Пермийн нүүрс агуулсан эх газрын тунамал хурдас, олигоцен, янз бүрийн гарал үүсэлтэй дөрөвдөгчийн хурдас өргөн тархалттай. Талбайн өмнөд хэсгээр Ихшанх формацын элсэн чулуу, алевролит, гравеллит, конгломерат, аргиллит, суурилаг болон хүчиллэг найрлагатай туф, туффитууд өргөн тархсан бол хойт хэсгээр нь дунд-дээд Девоны Цэцгэршанд формацын цахиурлаг андезит, элсэн чулуу, хаслаг кварцитууд тархжээ.

**Ашигт малтмалын илрэл:** Судалгааны талбайд Өмнөд Монголын минерагений бүс нь Манлайн зэсийн дэд бүст ялгагдана. Манлайн зэсийн дэд бүст, Ханхонгор Хармагтайн хүдрийн зангилаа алт зэсийн илрэл, зэсийн эрдэсжсэн цэг, алтны сарнилын хүрэнүүд тогтоогдсон. Тахилга уулын потенциал талбай (Ag), Хацарын потенциал талбай (Cu, Au), Овоот хяр, Хармагтайн потенциал талбайнууд ялгагдана. Чандмань уулын потенциал зангилаа, зэсийн эрдэсжсэн цэг болон зэсийн сарнилын хүрэнүүд тогтоогдсон. Их Шанхайн потенциал зангилаа – Алт зэсийн илрэл, эрдэсжсэн цэгүүд, молибдений сарнилын хүрэнүүд тогтоогдсон. Их Шанхайн хүдрийн потенциал талбай Cu-Mo-Au ялгагдана.

*Шүтээний хүдрийн зангилаа* – Зэсийн илрэл эрдэсжсэн цэгүүд болон сарнилын хүрэнүүд тогтоогдсон. Баян Хошууны Cu-Au, Pb-ын хүдрийн талбай, Шүтээн, Хан богдын Cu-Au-Mo, алуניתийн хүдрийн талбай, Хар Толгойн Cu-Au-ын хүдрийн талбай, Даш сүмийн Cu-Au-ын хүдрийн талбайнууд ялгагдана.

*Өмнөговийн нүүрсний сав газар* – Таван толгойн Пермийн нүүрсний дүүрэг нь Ухаа худаг, Бор Толгой, Онч хараат, Баруун Наран I-II, Цанхи (Таван Толгойн), зүүн өмнөд, баруун өмнөд гэсэн орд илрэлүүдтэй. Оюу толгой-Цагаан суваргын хүдрийн дүүрэг (Cu-Mo, Cu-Au, Au) нь Зогдор уулын потенциал талбай, зэсийн илрэл, эрдэсжсэн цэгүүд тогтоогдсон. Ханбогд-Лугийн голын ховор, ховор шороон металлын давхацмал хүдрийн дүүрэг ялгагдсан.

*Эдрэн-Номгоны минерагений бүс:* Даланзадгад-Булганы шатах ашигт малтмал агуулсан сав газар нь Сүүж Худгийн нүүрсний талбай, Жаргалантын нүүрсний талбайнуудад ялгагдана. Өмнөговийн нүүрсний сав газар нь Мухар Шандын нүүрсжилтийн талбай, Тулгын нүүрсжилтийн талбай нь Эрдэнэбулагийн нүүрсний орд тогтоогдсон. Аргалантын хүдрийн потенциал зангилаа (Au, Cu, Pb, Mn) нь Аргалантын алтны потенциал талбайд ялгагдана.

**Гадаргын ус:** Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын “Номгон-IX” талбай Өмнөговь аймгийн Баян-Овоо, Ханхонгор, Ханбогд, Цогтцэций, Цогт-Овоо, Номгон, Манлай сумдын нутагт орших бөгөөд тухайн бүс нутаг нь гадаргын ус байхгүй. Хур бороо орсон үед газрын

гадарга дээгүүр түр зуурын урсац үүсгэдэг ч удалгүй хөрсөнд шингэдэг. Хөрсний ус нь хур тунадасны ус ба хажуу гадаргаас хотгор руу урсах түр зуурын урсгал усны шингэлтээр тэжээгддэг. Иймд хайгуулын талбайд байнгын урсгалтай гадаргын урсац байхгүй, хур борооны түр зуурын үерийн усыг эс тооцвол хайгуулын ажилд хүндрэл учруулахгүй.

**Газрын доор ус буюу гидрогеологийн тогтоц:** Өмнөговийн тал болон хагас цөлөрхөг хуурай уур амьсгалтай геологийн нийлмэл тогтоцтой, ан цав багатай дүүрэг нь газар доорх ус бүрэлдэх хангалттай нөхцөл болж чаддаггүй тул газар доорх усны олон тооны жижиг бассейн, линз, давхаргууд үүсгэдэг бөгөөд давсархаг эсвэл давст устай байдаг. Өмнөговь аймгийн гүний урсацын модуль нь 0.02-0.05 л/с.км<sup>2</sup> ба уулын нуруудын зах хязгаарт хамгийн өндөр утгатай байна. Газар нутгийн хувьд газрын доорх усны нөхөн сэргэлт бага бүс нутагт хамаарна. Тухайн аймгийн газар нутгийн төвийн хотгор хэсгээс бусад ихэнхи хэсэгт говийн бор шавранцар хөрс үүсэж, гадуур нь элсэнцэр сайр хуримтлагдсанаар ус нэвтрэлт сайтай газар нутагт хамаарагдана. Газрын доорх усны нөхөн сэргэлт үндсэндээ атмосферийн хур тунадас болон чийгийн конденсацар явагдана. Тиймээс зуны бороотой үед газрын доорх усны түвшин 1.5-2 м-ээр нэмэгдэж, өвөл аажмаар бууран хавар хамгийн бага утгатай болохыг хөрсний усны горимоос харах боломжтой. Үерийн урсацыг бүрэн шингээх болон атмосферийн хур тунадасыг эрчимтэйгээр инфильтраци хийх чадвараар нь нийт газар нутгийн ихэнхи хэсэг антиклиналь бүсүүдэд хуваана. Уулсын зах хязгаараар үндсэн нөхөн сэргэлтийн мужууд байдаг.

Өмнөговь аймгийн дүүрэг нь гидрогеологийн 4 бүтэцтэй. Үүнээс метаморфик болон вулканоген чулуулгаас тогтсон гидрогеологийн массив юм. Ус нь хур тунадасны усны шүүрлийн үр дүнд бүрэлдэн, гидрогеологийн массив дах усны урсгалын дүнд артезийн усны бассейн үүсдэг бөгөөд уулс хоорондын хотгорт давхарга болон сүв-давхаргын ус, ан цавын ус агуулж тохиолддог. Дүүргийн өмнөд ба зүүн өмнө хэсэг интрузив чулуулгаас тогтсон. Тектоник хөдөлгөөнөөр чулуулгууд бутран газрын доорх усны эргэлт, хуримтлалд чухал нөлөө үзүүлдэг кристал чулуулгийн бүсийг үүсгэдэг. Дээрх газрын гадаргуугийн гидрогеологийн бүтцүүд нь рельефийн геоморфлогийн хэлбэрийг тодорхойлдог учир рельефийн хэлбэрээр нь газрын доорх усанд прогноз хийх боломжтой юм.

Өмнөговь аймгийн хойд хагаст орших уулсын массивын үлэмж өргөгдсөн төвийн хэсэг болон өмнөд хэсгийн бүх өргөгдсөн хэсэг ан цавтай уулын чулуулгуудаас тогтох бөгөөд хамгийн сул усан хангамжтай газар нутагт хамаарна. Уст цэгийн ундарга 0.1 л/с ба түүнээс ч бага байдаг.

**Хөрсөн бүрхэвч:** Өмнөговь аймгийн Ханхонгор, Номгон, Цогтцэций Баян-Овоо, Цогт-Овоо, Манлай, Ханбогд сумуудыг дамнан орших “Номгон-IX” хайгуулын талбай нь Монгол орны хөрс газарзүйн мужлалтаар Говийн их мужийн Говь Алтайн тойрог (52), Алтайн Өвөр тойрог (53), Заримдаг цөлийн цайвар бор хөрстэй дэд бүсийн Манлайн тойрог (11), Монголын өрнөд мужийн Даланзадгадын тойрог (33), Цөлийн бор саарал хөрсний бүсийн Галбын говийн тойрог (14), Заг Сүүж-Борзонгийн говийн тойрогт тус тус оршино.

*Говийн их мужийн* хойд хэсгээр цайвар хүрэн ба бор хөрс урагшаагаа цөлийн цайвар бор, гөлтгөнөт-улаавтар хөрс тархах ба мараалаг хөрсний эзлэх талбай ихэснэ. Хөрс үүсэх процесст салхины нөлөө их учир гадарга дээр нимгэн сайр чулуун хучаастай, нимгэн давхаргатай, сайр чулуу ихтэй байдаг нь говийн хөрсний онцлог шинж юм.

*Говь-Алтайн мужид* уулын цайвар хүрэн, бор хөрс голлон тархаж уулсын хоорондох өргөн хоолой, хотгорт элсэн манхан, хужир тойром элбэг тохиолдоно. Энэ мужид гөлтгөнөт болон цайвар бор хөрс тархсан. Ихээхэн хуурай уур амьсгалын нөлөөгөөр хөрсний босоо бүсшил

өвөрмөц шинжтэй илэрнэ. Бор Цонжийн говиор бусдаасаа арай чийглэг бөгөөд сулавтар мараалаг ба хааяа гөлтгөнө агуулсан цайвар бор хөрс голлож, хужир, мараа ихээхэн тархсан. Сулавтар мараалаг цайвар бор хөрс, гөлтгөнөт улаавтар хөрс бүхий чулуурхаг цөл Алтайн өвөр говьд их талбай эзэлнэ. Сүүж, Борзон, Галбын говиор мараалаг цайвар бор хөрс голлож мараа ихтэй, элсэн манхан, хужир марз, шал тойром нэлээд элбэг.

**Цөлөрхөг хээрийн (говийн) бор хөрсний бүс.** Энэ бүсэд хөрсний ерөнхий шинж нь үе давхаргууд тод илэрсэн, сайргархаг, ялзмаг багатай, өнгөнөөс эсвэл дээд давхаргаас буцлах ба мараалаг шинжгүй, ус чийгээр дутмаг, гөлтгөнөгүй, сайр чулуугаар хучигдсан байдаг. Говь цөлийн хөрсний онцлог шинж хотгор хонхор, хотос газраар хужирлаг, мараалаг хөрстэй бөгөөд элсэн хуримтлал ихээхэн тархжээ.

**Цөлийн цайвар бор (бор саарал) хөрсний бүс.** Талархаг нутагт тархсан заримдаг цөлийн ба цөлийн хөрсний үндсэн 3 хэв шинжид цөлөрхөг хээрийн бор, цөлийн бор саарал, цөлийн борзон хөрс орно. Цөлийн хөрсөнд улаавтар өнгө зонхилох ба бөөмөрхөг, самарлаг маягийн бүтэцтэй, ялзмагт давхарга бараг байхгүй, зөвхөн иллювиаль үеийн дээд хэсэгт бүдэг ажиглагдана. Хөрсний карбонатын орших гүн нэг зүсэлтийн өөр өөр хананд ч ялгаатай байх ба заримдаа давсны хүчилд буцлахгүй толбо маягаар тохиолддог. Говийн бор хөрсний гадаргын айран хучаасны дор цайвар өнгийн сүвэрхэг хатуу үе бий энэ үеийн дор цайвар саарал туяатай хуудаслаг нимгэн давхарга тогтсон байдаг нь ялгарах гол шинж болно. Энэ бүс нь уулсын бэл хормой, уулс хоорондын хотгор, хоолой, цав толгод хуурай сайр ихтэй бөгөөд хур тунадас элбэг жилд түр зуурын урсацаар зөөгдсөн хурдас ихтэй. Хөрсний гадарга нь цөлийн гандаас бүхий сайр чулуугаар бүрхэгдсэн байдаг нь цөлийн хөрсний нийтлэг дүр төрхийг илтгэнэ. Хучаас үе нь хөрсний өнгөн хэсгийг дефляци, хэт халалтаас хамгаалдаг учраас ууршилт, ус-чийгийн горим, биологийн үйл явцад зохиох хэмжээгээр нөлөөлдөг.

Ерөнхий хөрсөн бүрхэвч нь доворхог хад чулуурхаг газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог, хоршил зонхилоно. Өндөрлөгдүү уулархаг газраар нимгэн чулуурхаг, хотгордуу газраар ердийн Говийн цайвар бор хөрстэй. Хойд хэсгээр нимгэн чулуурхаг хөрстэй байхад, урд хэсгийн хотгордуу газраар элсэрхэг дов ихтэй элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нилээд их талбай эзэлж байна. Хотгордуу газраар мараалаг хужирлаг шинжийн давсархаг хөрс хам бүрдэл үүсгэж бага зэрэг талбай эзэлнэ.

**Ургамлан нөмрөг:** Монгол орны ургамал газарзүйн мужлалаар төслийн талбай нь Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог, Говь-Алтай уулын цөлөрхөг хээрийн тойрог, Алашаа говийн тойрогт тус тус багтах (Өлзийхутаг, 1982) ба экосистемийн хувьд цөлийн хээрт хамаарна. Говийн цаг уур, хөрсний онцлогоос шалтгаалан ургамалын нягтшил багатай, сийрэг тачир, хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. “Номгон-IX” талбайд тархсан ургамалжилтын төрлийг зураглалаар гаргав.

Судалгааны талбайд 11 овог, 20 төрлийн, 28 зүйл ургамал бүртгэгдсэн. Ховор болон нэн ховор ургамал байхгүй. Цөлжүү хээр, хээржүү цөл, цөлийн хэв шинжийн ургамалжилттай байна.

**Амьтны аймаг:** “Номгон-IX” талбайд хамаарах нутаг дэвсгэрт өмнө нь хийгдсэн судалгааны дүнгээс үзэхэд<sup>1</sup> хөхтөн, шувуу, мөлхөгчдын гэх 3 ангид хамаарах 46 зүйлийн сээртэн амьтад идээшин нутаглаж байна. Үүнээс 4 баг, 6 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйлийн хөхтөн, 16 зүйл шувуу, 8 зүйл мөлхөгчид тархжээ. Тухайн бүс нутагт тархсан сээртэн амьтдыг амьдралын

<sup>1</sup> “Номгон-IX талбайд НДМХ хайгуул хийх төсөл”-ийн БОННУ-ний тайлан, Глобал энвайрон ХХК, 2019

хэлбэрээр ангилж үзвэл нийт сээртэн амьтдын 17 хувь суурин бөгөөд ичээлдэггүй, 33 хувь нь ичээлдэг, 50 хувь нь нүүдлийн амьтад нутаглаж байна.

**Тусгай хамгаалалттай газар нутаг:** “Номгон-IX” НДМ хийн хайгуулын талбай нь Улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй. Харин аймгийн болон тухайн сумдын ИТХ-ын тогтоолын дагуу орон нутгийн тусгай хамгаалалттай 43 газар нутагтай хэсэгчлэн болон бүрэн давхцалтай байна. Үүнд аймгийн хамгаалалтанд авсан 11 газар, сумын хамгаалалтанд авсан 32 газар байна.

Тусгай хамгаалалтад авсан зориулалтаар нь авч үзвэл Байгаль, түүхийн дурсгалт газар 15, Ой, амьтан, ургамал, усны нөөц газар 26, бусад зориулалтаар 3 газрыг аймгийн болон сумын ИТХ-ын тогтоолоор хамгаалалтад авсан байна.

Тусгай хамгаалалтад авсан зорилго нь 16 газрыг Байгалийн нөөцөд, 11 газрыг Байгалийн унаган төрх, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, 5 газрыг Байгалийн экологийн тэнцвэрийг хадгалах, 3 газрыг Дурсгалт газрыг хамгаалах, харин Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах болон Хадлангийн талбайн зорилгоор тус бүр 1 газрыг хамгаалалтад авчээ.

**Нийгэм-эдийн засаг<sup>2</sup>:** “Номгон-IX” талбай нь Баян-Овоо, Манлай, Ханбогд, Ханхонгор, Номгон, Цогтцэций, Цогт-Овоо сумдын нийт газар нутгийн 36.8 хувийг эзлэнэ. Талбайд хамаарах сумдын хүн амын нягтрал, аймгийн төвөөс алслагдсан зай болон багийн тоог доорх хүснэгтэд харуулав.

#### Хүснэгт 4. Сумдын хүн ам, өрхийн үзүүлэлт

№	Сумдын нэр	2021 оны эцэст		Хүн амын нягтрал /1 км <sup>2</sup> -д ноогдох хүн/	Аймгийн төвөөс сум хүртэлх зай, км	Багийн тоо
		Хүн амын тоо	Өрхийн тоо			
1.	Баян-Овоо	1830	588	0.2	165	3
2.	Манлай	2711	762	0.2	225	4
3.	Номгон	2494	825	0.1	110	5
4.	Ханбогд	8079	2116	0.5	270	5
5.	Ханхонгор	2013	828	0.2	25	4
6.	Цогт-Овоо	1952	624	0.3	120	3
7.	Цогтцэций	8619	2643	1.2	100	4

Төсөл хэрэгжиж буй сумдын хүн амын нягтрал буюу 1 км<sup>2</sup> талбайд ноогдох хүний тоо Цогтцэций сум 1.2 буюу хамгийн их, Номгон сум 0.1 байна. Өрхийн тоогоор Ханбогд болон Цогтцэций сумд хамгийн их байна. Тухайлбал 2021 оны жилийн эцэст Ханбогд суманд 2116 орчим, харин Цогтцэций суманд 2643 өрх байсан бол бусад сумдын хувьд 588-828 хооронд байна. Энэ нь өмнөх 2 сумдаас даруй 2-3 дахин бага байна. Ханбогд, Цогтцэций сумдын хувьд манай улсын уул уурхайн томоохон төсөл хөтөлбөр (Оюутолгой, Тавантолгой болон бусад) хэрэгждэг бөгөөд үүнээс шалтгаалсан хүн амын шилжих хөдөлгөөнд өөрчлөлт орж, байнгын бус оршин суугчид ч эрс нэмэгдэж байгаа юм.

### 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч

Магадлан жагсаах аргаар нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэх бөгөөд тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодорхойлно.

<sup>2</sup> Өмнөговь аймгийн статистикийн хэлтэсийн мэдээ

**Хүснэгт 5. Гол болон болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим**

№	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн хэлбэр		Нөлөөллийн хугацаа		Нөлөөллийн эрчим		
		Шууд	Шууд бус	Богино хугацааны	Урт хугацааны	Хүчтэй	Дундзэрэг	Багазэрэг
<b>Агаарын чанар</b>								
1.	Хүнд даацын машин техникийн түлшний шаталтаас агаарт бохирдуулагч хий ялгарах, тээвэрлэлтийн үеийн тоосжилт нь орон нутгийн агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.	-		х			х	
2.	Хүчтэй салхины нөлөөгөөр элэгдэлд орсон газрын гадаргуугаас шороо тоос босох		-	х			х	
<b>Усан орчин</b>								
3.	Өрөмдлөгийн технологит газрын доорх усны нөөцийн ашиглалт	-		х				х
4.	Шингэн хаягдлын сангийн байгуулалт, хийцлэл шаардлага хангахгүй байх, зориулалтын бус материал ашиглах зэргээр хөрс, хөрсний усны бохирдол үүсгэх		-	х			х	
<b>Хөрс, газрын гадарга</b>								
5.	Тээвэрлэлтийн үед орон нутгийн шороон замын эвдрэл, олон салаа зам гарах	-		х			х	
6.	Ахуйн хатуу хог хаягдлыг их хэмжээгээр ил задгай хуримтлуулах, орчинд тархах		-	х			х	
7.	Түлш, тосолгооны материалыг ил задгай байршуулах, зориулалтын бус саванд хадгалах зэргээр хөрсний бохирдол үүсгэж болзошгүй		-	х			х	
8.	Кемп байгуулах, суваг татах, өрмийн тоног төхөөрөмж суурилуулах зэрэг тодорхой байршлуудад хөрс, газрын гадаргын төрх байдалд өөрчлөлт орж, тухайн газрын хөрсөн бүрхэвч шууд нөлөөлөлд өртөнө.	-		х		х		
<b>Ургамал</b>								

№	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн хэлбэр		Нөлөөллийн хугацаа		Нөлөөллийн эрчим		
		Шууд	Шууд бус	Богино хугацааны	Урт хугацааны	Хүчтэй	Дундээр	Багазэрэг
9.	Кемп, өрмийн талбай, суваг татах зэргээр бага хэмжээний газруудын ургамлан нөмрөг шууд нөлөөлөлд өртөх, тээврийн хэрэгслийн нөлөөнөөр тухайн орчны ургамлан нөмрөг талхлагдах олон салаа зам үүсэх зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй.	-		х		х		
<b>Амьтан</b>								
10.	Тоног төхөөрөмжийн тээвэрлэлтэд ашиглах том оврын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, мөн зөөврийн цахилгаан үүсгүүрийн дуу чимээгээр тухайн бүс нутгийн хөхтөн амьтад үргэн дайжих		-	х				х
11.	Өрмийн шингэн хаягдлын сангийн хашаа хамгаалалтыг стандартын дагуу хийгээгүйгээс мал, амьтад орох, унах		-	х				х
<b>Бусад</b>								
12.	Ажилчдын ундны усны шаардлага хангагдахгүй байх		-	х				х
13.	Цахилгаан үүсгүүр, өрмийн бусад тоног төхөөрөмжөөс гарах өндөр дуу шуугиан нь ажилтнуудын сонсголын эрхтэнд сөргөөр нөлөөлөх		-	х			х	
14.	Ойролцоох малчин айл өрхийн амьдрах орчинд дуу шуугиан, тоосжилтын нөлөөлөл үүсэх, малын бэлчээрлэлт хумигдах		-	х				х
<b>Нийлбэр дүн</b>		<b>5</b>	<b>9</b>	<b>14</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>7</b>	<b>5</b>



#### 4. БОМТ-НИЙ гол зорилт, хамрах хүрээ

**Зорилго, зорилт:** “Номгон-IX” талбайд Нүүрсний давхаргын метан хийн хайгуул хийх төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө, 2019 онд “Глобал энвайрон” ХХК-ийн боловсруулсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжиж буй орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Жи Өү Эйч” ХХК-ийн Өмнөговь аймгийн Баян-Овоо, Ханхонгор, Ханбогд, Цогтцэций, Цогт-Овоо, Номгон, Манлай сумдын нутгийг хамарсан, “Номгон-IX” хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд “Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын ажил гүйцэтгэх” төслийн 2023 оны БОМТ-г боловсруулахдаа Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, төслийн 5 жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв, төлөвлөгөөтэй уялдуулан БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

**Хамрах хүрээ:** Энэхүү төлөвлөгөөгөөр “Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын ажил гүйцэтгэх” төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон.

## 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

### Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Агаар</b>									
1.	Хийн алдагдал үүсэж, орчны агаар дах метан хий болон бусад дагалдах хийн шаталтаас эрсдэл үүсэх	Өрөмдлөгийн аюулгүй ажиллагааг ханган ажиллах	Эрлийн цооног Стратиграфийн цооног (нунтаг дээжтэй), Үнэлгээний цооног (Чөмгөн дээжтэй)	Тууш метр	Үйл ажиллагааны зардал	9	Үйл ажиллагааны зардал	Хээрийн ажлын шатанд	Олон улсын цооног өрөмдлөгийн аюулгүй ажиллагааны шаардлагууд болон Монгол улсын стандартын дагуу
2.	Бүрэн бус тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Хайгуулын ажилд ашиглах машин техникийг авто тээврийн улсын үзлэгт хамруулах	Авто тээврийн хэрэгслүүд	ш	Үйл ажиллагааны зардал	9-10 техник	Үйл ажиллагааны зардал	Авто тээврийн улсын дугаарлалтын хуваарийн дагуу	Агаарын тухай хуулийн 3.1.14
3.	Агаарт тоосжилт үүсэх, хөрс эвдрэх	Кемп, өрмийн талбайн хооронд тогтсон чиглэл маршрутаар зорчих. Олон салаа зам гаргахгүй байхад анхаарна.	Шороон замаас үүсэх тоосжилт	-	-	тогтмол	-	Хээрийн ажлын шатанд	Агаарын тухай хуулийн 9.1.7
<b>Ус</b>									
4.	Газрын доорх усны нөөцийг зөвшөөрөлгүй ашиглах	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээ байгуулах, төлбөр төлнө	Өрөмдлөг	6000.0 тууш.м	Гэрээнд тусгагдсан дүнгээр үйл ажиллагааны зардал	600.0 м <sup>3</sup>	Үйл ажиллагааны зардал	Өрөмдлөгийн шатанд	Усны тухай хуулийн 28.4, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6.1.2, 10.1.3, 15.1,



№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
									БОНХАЖ-ын сайдын А/301 дүгээр тушаалын 2 хавсралт
<b>Хөрсөн бүрхэвч, газрын гадарга</b>									
5.	ШТМ хөрсний гадарга дээр асгарч хөрс, газрын гадаргад бохирдол үүсгэх	Машин техникийн засвар үйлчилгээ хийхэд үл нэвчих геомемберан дэвсгэр дэвсэх, хөрс бохирдохоос хамгаална.	Техник хэрэгсэл	удаа	-	тогтмол	Үйл ажиллагааны зардал	Өрмийн ажил, хээрийн ажлын шатанд	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 9.3
6.	Хөрсний эвдрэлд орох	Өрмийн талбайг хүрээ татан тэмдэгжүүлж, хөрсний эвдрэлээс сэргийлнэ.	Өрмийн талбай		Үйл ажиллагааны зардал	-	1 000 000	Талбайн бэлтгэл шатанд	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 9.3
